



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Сүхбаатар

“Гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлж, хүний нөөцийг
бэхжүүлэх жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.9, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар төр төсвийн байгууллагын үйл ажиллагааны чадавхи, үр нөлөө, төрөөс иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оныг “Гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлж, хүний нөөцийг бэхжүүлэх жил” болгон зарласугай.

2.Зарласан жилийн төлөвлөгөөг 1-р хавсралтаар баталсугай.

3.Зарласан жилийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагынхаа онцлогт тулгуурлан бодлого, зорилт дэвшүүлсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг төр, төсвийн нийт байгууллагын төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4.Зарласан жилийн ажлын биелэлтийг хянах, удирдлага зохицуулалтаар хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА